ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 16 өдөр Дугаар А/361 Улаанбаатар хот

Ажлын даалгавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.8, 23.1.11 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.10 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар тогтоол, Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/152, А/153 дугаар тушаал, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 23-ний өдрийн 02/3065 дугаартай "Чиглэл хүргүүлэх тухай" албан бичиг, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2025 оны А/287 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Бизнес инкубацийн туршилтын хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх, сургалт, зөвлөгөө, дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын даалгавар хавсралтаар баталсугай.

2."Бизнес инкубацийн туршилтын хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг зохион байгуулж, ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газар (М.Эрдэнэбулган)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалт дотоод аудит мониторингийн газрын дарга (М.Мянганбуу)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ З.БАУЫРЖАН

0000000001626

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын
түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 10 дугаар сарын 16-ны
өдрийн А/361 тушаалын хавсралт

НЭГ БИЗНЕС ИНКУБАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ, СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨ, ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

Ажлын төрөл	Ажил гүйцэтгүүлэх
Ажлын зорилго	Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон бизнес эрхлэхийг хүссэн иргэн, зорилтот бүлгийн иргэн, түүнчлэн малчинд мэдээлэл, мэргэжлийн зөвлөгөө өгөх, аж ахуй эрхлэх ур чадвар эзэмшүүлэх, байр түрээслүүлэх, түншлэл, борлуулалтын дэмжлэг үзүүлэх зэргээр инкубацийн үйлчилгээг үзүүлж, аж ахуй эрхлэх таатай орчныг бүрдүүлж шинэ ажлын байр бий болгох, тогтворжуулахад чиглэнэ.
Захиалагч тал	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар. Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Өөрийн байр, Улаанбаатар 17042. Утас:77771220
Гүйцэтгэгч тал	Монгол Улсын хуулийн этгээд, бичил бизнес эрхлэгч
Үргэлжлэх хугацаа	Төслийн хэрэгжих хугацаа 8 сар
Хийгдэх ажил	**1. Холбогдох сургалт зохион байгуулах**: **1.1.** Бизнесийн сургалт зохион байгуулах (нийт 100 оролцогчид зориулсан бизнесийн суурь мэдлэг, төсөл, бизнес төлөвлөгөө боловсруулах, менежмент, маркетинг, хөдөлмөрийн аюулгүй байдал, хууль эрхзүйн сэдвээр сургалт явуулах); **1.2.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон хувь хүний хөгжлийн сургалт зохион байгуулах (нийт 100 оролцогчийн хувийн ур чадвар (манлайлал, харилцаа, цагийн менежмент, стрессийн удирдлага гэх мэт) хөгжүүлэх сургалт зохион байгуулах). **2. Зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээ:** **2.1.** Бизнес инкубацийн төвийн менежер, зөвлөхийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх (8 сарын хугацаанд бойжигч бизнесүүдэд өдөр тутмын зөвлөгөө, хяналт, менторинг үзүүлэх); **2.2.** Сургагч багш, салбарын зөвлөхүүдийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа (Бойжигчдын хэрэгцээнд нийцсэн мэргэжлийн зөвлөх үйлчилгээг сар бүр үзүүлэх (маркетинг, борлуулалт, санхүү, татвар, хууль эрх зүйн чиглэлээр). **3. Бизнес инкубацийн дэмжих үйлчилгээг хэрэгжүүлэх:** **3.1.** Ажлын байр, тоног төхөөрөмжийн түрээсийн хөнгөлөлт олгох (10 -12 хүртэлх бойжигчид ажиллах орон зай, оффисын тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй нөхцлөөр ашиглуулах); **3.2.** Мэдээлэл, технологийн үйлчилгээ үзүүлэх (Вэбсайт хөгжүүлэлт, сошиал медиа менежмент, контент бэлтгэл, хиймэл оюун ухаанд суурилсан маркетингийн дэмжлэг үзүүлэх); **3.3.** Зах зээлд холбох, борлуулалтыг дэмжих үйлчилгээ үзүүлэх (Бойжигчдыг үзэсгэлэн, экспо, онлайн платформуудад холбон борлуулалтын сувгуудыг өргөжүүлэх, харилцагчийн сүлжээ байгуулах); **3.4.** Санхүүжилт олоход туслах үйлчилгээ үзүүлэх (Санхүүгийн байгууллагатай холбох, төсөл бичихэд дэмжлэг

	үзүүлэх, хөрөнгө оруулагчидтай уулзалт зохион байгуулах); **3.5.** Бусад дэмжих үйлчилгээ үзүүлэх (Бойжигчдын хэрэгцээнд нийцсэн туслах үйл ажиллагаа буюу сургалтын дараах дагалдан сургалт, бизнесийн арга хэмжээ, танилцуулга өдөрлөг гэх мэт).
Хүлээгдэж буй үр дүн	**1. Сургалтад иргэд хамрагдсанаар:** **1.1.** Бизнесийн болон аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулснаар дараах үр дүн гарна. Үүнд: • Нийт 100 оролцогч аж ахуй эрхлэлт, бизнесийн суурь мэдлэг, менежмент, маркетинг, хууль, хөдөлмөрийн аюулгүй байдлын мэдлэг эзэмшинэ. • Нийт 100 оролцогч бизнес төлөвлөгөө, төсөл боловсруулах анхан шатны мэдлэг, чадвартай болно. • Оролцогчдын бизнесийн эрсдэл тооцох, шийдвэр гаргах чадвар дээшилнэ. **1.2.** Хөдөлмөр эрхлэлтийн болон хувь хүний хөгжлийн сургалт зохион байгуулснаар дараах үр дүн гарна. Үүнд: • 100 оролцогч хөдөлмөр эрхлэлтийн болон манлайлал, харилцаа, цагийн менежмент, стрессийн удирдлагын ур чадвар эзэмшинэ. • Оролцогчдын ажлын бүтээмж, урам зориг, өөртөө итгэх итгэл нэмэгдэнэ. • Инкубацийн бойжигчдын багийн хамтын ажиллагаа, дотоод соёл сайжирна. **2. Зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээний хүрээнд:** **2.1.** Менежер, зөвлөхийн үйл ажиллагааг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна. Үүнд: • 10 - 12 хүртэлх бойжигч байнгын ментор, зөвлөгөө, хяналтын үйлчилгээ авна. • Сарын тайлан, дүн шинжилгээ, зөвлөмжийн систем бүрдэнэ. • Бизнесүүдийн үйл ажиллагааны үр ашиг, зохион байгуулалт сайжирна. **2.2.** Сургагч багш, салбарын зөвлөхүүдийн зөвлөгөөний үр дүн: • Бойжигчид маркетинг, борлуулалт, татвар, санхүү, хууль эрх зүйн чиглэлээр мэргэжлийн дэмжлэг авна. • Бизнесийн стратеги, бүтээгдэхүүн үйлчилгээний чанар дээшилнэ. • Бойжигчдын асуудлыг шийдвэрлэх чадавх нэмэгдэнэ. **3. Бизнес инкубацийн дэмжих үйлчилгээг үзүүлснээр:** **3.1.** Түрээсийн хөнгөлөлтийн үр дүнд: • 10 - 12 хүртэлх бойжигч тогтвортой ажлын байр, оффисын орчинд үйл ажиллагаа явуулах нөхцөлтэй болно. • Эдийн засгийн дарамт буурч, үндсэн үйл ажиллагаандаа төвлөрөх боломж бүрдэнэ. **3.2.** Мэдээлэл, технологийн үйлчилгээ үзүүлснээр: • 10 бойжигч байгууллага вэбсайт, сошиал медиа хуудас, онлайн сурталчилгаа бүхий цахим орчинд өөрийн байр суурьиа бий болгоно. • Хиймэл оюун ухаанд суурилсан контент, маркетингийн шийдэл туршина. • Бүтээгдэхүүний нэр хүнд, хэрэглэгчийн хүртээмж нэмэгдэнэ.

	3.3. Зах зээлд холбох, борлуулалтыг дэмжих үйлчилгээнд хамрагдснаар: • Бойжигчид экспо, үзэсгэлэн, худалдааны арга хэмжээнд оролцоно. • Борлуулалтын сүлжээ, хэрэглэгчийн бааз тэлнэ. • Харилцагчийн тогтвортой сүлжээ, гэрээ хэлцэл бий болно. **3.4.** Нэмэлт санхүүжилт олоход туслах үйлчилгээг авснаар: • Бойжигч бүр санхүүгийн байгууллагатай холбогдох, төслөө танилцуулах чадвартай болно. • Санхүүжилт, хөрөнгө оруулалт татсан бизнесүүдийн тоо нэмэгдэнэ. • Санхүүгийн менежмент, тайлагналын чадамж дээшилнэ. **3.5.** Бусад дэмжих үйлчилгээний үр дүнд: • Дагалдан сургалт, бизнесийн өдөрлөг, танилцуулга зохион байгуулж, бизнесүүдийн хамтын ажиллагаа өргөжнө. • Бойжигчдын сүлжээ, туршлага солилцох орчин бий болно. • Инноваци, хамтын санаачилга дэмжигдэнэ. Эндээс дараах үр дүн бий болно. Үүнд: • Нийт 100 оролцогч сургалтад хамрагдан мэдлэг, ур чадвар эзэмшинэ. • 10 – 12 хүртэлх бойжигч байгууллага иж бүрэн инкубацийн дэмжлэг авна. • Бойжигчдын 80 хувиас дээш нь үйл ажиллагаагаа бие даан тогтвортой явуулах чадамжтай болно. • Орон нутгийн ажил эрхлэлт, жижиг, дунд үйлдвэрлэл, бизнесийн хөгжилд бодит хувь нэмэр оруулна.
Сонгон шалгаруулалтад орох төрийн бус байгууллагуудад тавигдах шаардлага	**I. Ерөнхий шаардлага:** • Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэлтэй, үйл ажиллагаа нь хүчин төгөлдөр хуулийн этгээд; • Үйл ажиллагааны чиглэлдээ бизнесийн хөгжил, сургалт, зөвлөгөө, инновац, гарааны бизнес, аж ахуйн нэгжийн дэмжлэг зэрэг холбогдох чиглэл тусгагдсан байх; • Сүүлийн 2–3 жилд бизнесийн сургалт, зөвлөгөө, инкубацийн чиглэлээр туршлага хуримтлуулсан байх; • Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ зөрчөөгүй байх; • ТББ нь татвар, нийгмийн даатгалын өр төлбөргүй байх. • Санхүүгийн үйл ажиллагаа нь ил тод, тайлагналтай аудитын дүгнэлттэй байх. **II. Хүний нөөцийн чадавхи:** • Бизнес инкубацийн менежер, зөвлөх, ментор ажиллуулах хүний нөөцийн бүрэлдэхүүнтэй байх; • Доорх чиглэлүүдээр мэргэжлийн сургалт, зөвлөгөө үзүүлэх чадвартай сургагч багш, зөвлөх багтай байх бөгөөд эдгээр нь: ✓ Бизнесийн менежмент; ✓ Харилцааны ур чадвар, сэтгэл зүй; ✓ Санхүү, татвар; ✓ Маркетинг, борлуулалт; ✓ Хууль эрх зүй; ✓ Мэдээллийн технологи, цахим маркетинг; ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, хүний нөөцийн

	менежмент. • Сургалт, зөвлөгөөний үйл ажиллагааг хариуцах ажилтнууд нь мэргэжлийн зэрэг, гэрчилгээ, туршлагын тодорхойлолт бүхий байх. **III. Материаллаг бааз, дэд бүтэц:** • Инкубацийн үйлчилгээ үзүүлэх ажлын байр, сургалтын танхим, оффисын байр байх; • Тоног төхөөрөмж, технологийн нөөц (компьютер, интернет, проектор, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сургалтын хэрэгсэл) хангалттай байх; • Цахим орчинд үйлчилгээ үзүүлэх чадвартай байх (вэбсайт, сошиал хуудас, онлайн сургалт явуулах платформ). **IV. Үйл ажиллагааны туршлага, хэрэгжилтийн чадавхи:** • Өмнө нь хэрэгжүүлсэн бизнесийн сургалт, инкубацийн хөтөлбөр, төслүүдийн тайлан, үр дүнгийн баримт танилцуулах; • Орон нутгийн бизнес эрхлэгчидтэй, төрийн байгууллага, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааны туршлагатай байх; • Үйл ажиллагаагаа төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах чадавхтай байх; • Үйл ажиллагааны дотоод журам, ил тод байдлын бодлого, жендэрийн болон нийгмийн оролцооны бодлого хэрэгжүүлдэг байх. **V. Санхүү, менежментийн чадавхи:** • Төрийн худалдан авах ажиллагааны хүрээнд хуваарилагдах санхүүжилтийг зориулалтын дагуу, үр ашигтай ашиглах менежментийн тогтолцоотой байх; • Нягтлан бодох бүртгэл, тайлагналын тогтолцоо бүрдсэн байх; • Санхүүгийн хяналт, дотоод аудитын арга хэмжээ хэрэгжүүлж чаддаг байх. **VI. Хүлээгдэж буй гол үр дүнд чиглэсэн чадавхи:** • Бизнес инкубацийн үйлчилгээг үр дүнтэй хэрэгжүүлж, доорх үзүүлэлтүүдийг хангах чадамжтай байх бөгөөд эдгээр нь: ✓ 100 оролцогчийг сургалтанд хамруулах; ✓ 10 -12 хүртэлх бойжигчид иж бүрэн дэмжлэг үзүүлэх; ✓ Шинэ бизнес санаа, инноваци, хамтын санаачилга бий болгох; ✓ Сургалт, зөвлөгөө, дэмжлэгийн нөлөөллийн үр дүнг хэмжих, тайлагнах.

~~~o0o~~~
~~~